

# ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ

ӨРГӨДӨЛ БҮРДҮҮЛЭХ - ЭЛСЭЛТ ӨГӨХ

Их, дээд сургууль, факультет бүр элсэлтийн өргөдөл гаргах хугацаа, суралцах нөхцөл, элсэлтийн журмын нөхцөлүүд өөр өөр байж болно. Та шаардлагатай бүх мэдээллийг тухайн их, дээд сургуулийн цахим хуудаснаас авах боломжтой.

**Ер нь ихэнх их, дээд сургуулиуд хуанлингийн жилийн 2-р сарын 28-ийг хүртэл бүртгэлийн хүсэлтийг хүлээн авдаг.**

Та их, дээд сургуулиудын тоймыг (улсын, нийгмийн, хувийн, гадаадын) эндээс авах боломжтой: <https://www.msmt.cz/vzdelavani/vysoke-skolstvi/prehled-vysokych-skol-v-cr-3>



## Элсэлтийн шалгалт:

- 5, 6-р сарын дундуур болдог (өргөдөл гаргагч урилга хүлээн авна).
- Элсэлтийн шалгалтын явц янз бүр байдаг.
- Амралт эхлэхээс өмнө өргөдөл гаргагчийг сургуульд элсэн орсон эсэхийг мэдэгдэнэ.
- Зуны амралтын үеэр - 7, 8-р сард их, дээд сургуулиудын зарим мэргэжлүүд 2-р шатны элсэлтийн шалгалтын гаргадаг. Гэсэн хэдий ч, энэ нь зөвхөн шалгалт өгөх ирц бүртгэлээс хамаарна.

Хэрэв та SCIO тестээр шалгалтад өгөх гэж байгаа бол эндээс туршиж үзэх боломжтой. <https://www.vysokeskoly.cz/scio-testy/>



## Бүртгэл:

- Ихэвчлэн цахимаар байдаг (та өргөдлийг хэвлэж, захиргааны хураамж төлсөн баримтын хамт шуудангаар сургалтын хэлтэст хүргэх шаардлага тулгарч магадгүй).
- Та маягтыг тухайн их сургуулийн цахим хуудаснаас (Цахим өргөдөл) олж болно.
- Бүртгүүлсэн өргөдөл бүрийн хувьд тухайн сургуулийн нөхцөл байдлын дагуу 600-900 крон захиргааны хураамж төлөх шаардлагатай.
- Өргөдлийн маягтад бөглөхдөө: овог нэр, оршин суугаа газрын хаяг, регистрийн дугаар, их, дээд сургуулийн нэр, факультет болон суралцах чиглэл, ерөнхий боловсролын сургуулийн дэлгэрэнгүй мэдээлэл

### Сургалтын хэлбэрүүд

Өдрийн - бүтэн цагийн сургалт	Хосолсон - зайны сургалт
<ul style="list-style-type: none"><li>- хичээлүүд хуваарийн дагуу ажлын өдөр бүр явагдана</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>- хичээлүүд хуваарийн дагуу ихэвчлэн баасан, амралтын өдрүүдэд явагддаг</li><li>- сургалт нь хөдөлмөр эрхэлж буй хүмүүст тохиромжтой</li></ul>

**Хэрэв танд тусламж хэрэгтэй бол PPI боловсролын хэлтсийн ажилтнуудтай холбоо барьж болно - [usti@p-p-i.cz](mailto:usti@p-p-i.cz).**



Spolufinancováno  
Evropskou unií



MINISTERSTVO VNITRA  
ČESKÉ REPUBLIKY



Projekt "Centrum na podporu integrace cizinců v Ústeckém kraji" reg. č. CZ.12.01.02/00/23\_008/0000008 je financován OP AMIF a MV ČR.